



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/542

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а" дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Л. Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч)

Гишүүд: Ж. Батбилэг (Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)

Н. Дэлгэрмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б. Цагаанчулуу (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)

Б. Ширчмаа (Эрүүл мэндийн газрын орчны эрүүл мэнд, хүнс тэжээл хариуцсан мэргэжилтэн)

П. Батбаяр (Онцгой байдлын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах дэслэгч)

Т. Ганбаяр (Цагдаагийн газрын Замын цагдаагийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч)

Б. Мөнхнасан (Нийгмийн даатгалын хэлтсийн Магадлагч эмч)

Д. Баатарсүрэн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын материал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д. Дэнсмаа (Стандарт хэмжил зүйн хэлтсийн Баталгаажуулалтын шинжээч)

О. Цэнгэлмаа (Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургагч багш, арга зүйч)

Б. Мөнхчулуун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Позитивийн сургагч багш)

Д. Ганчимэг (Худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Э.Цэвэлмаа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга)

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг "Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулъя-Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тогтолцоог бэхжүүлэе" уриан дор өрнүүлж, тус аяны хүрээнд хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажлын байрны соёлыг төлөвшүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулж, ажлын тайлангаа 2021 оны 05 дугаар сарын 07-ны дотор холбогдох газарт хүргүүлэхийг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  М.АНХБАЯР

481210287